МОНГОЛЫН АНАГААХЫН ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХОЛБОО

unesco Partnership

Эмнэлзүйн хиймэл оюуны ёс зүйн талаар бариmтлах

УЛААНБААТАРЫН ЗАРЧИМ

Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун, дэвшилтэт технологи хурдацтайгаар нэвтэрч, хэрэглэх болсон учир хүний нэр төрийг хүндэтгэх, мэргэжилтний үнэ цэнийг хадгалах зорилгоор эмнэлзүйн хиймэл оюуны ёс зүйн талаар баримтлах дараах арван зарчмыг баталж байна. Уг зарчмыг хиймэл оюунд суурилсан технологийн шийдлийг санаачлах, төлөвлөх, төсөвлөх, туршихаас хэрэглээнд нэвтрүүлэх бүх мөчлөгт баримтлан ажиллавал зохино.

ХҮНИЙ НЭР ТӨР

Нэг. Эрүүл мэндийн өгөгдлийн эмзэг байдлыг ухамсарлан хиймэл оюуны судалгаа, төлөвлөлт, хөгжүүлэлт, хэрэглээний бүхий л үе шатанд хүний эрхэм чанар, нэр төр, алдар хүнд, хувийн мэдээллийг хамгаалж хүндэтгэнэ. Хувь хүний эрхэм чанар, мэдээллийг хүндэтгэж, хувь хүний өгөгдлөөс илүүтэй хүний нэр төрд ач холбогдол өгч, анхаарна.

Хоёр. Эрүүл мэндийн хиймэл оюуны шийдвэр, түүнтэй адил үйлдэл бүрийг хүн хянан зохицуулах ба хүний шийдвэр гаргах бие даасан байдлыг хамгаалж хүндэтгэнэ.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гурав. Эрүүл мэндийн хиймэл оюун нь аюулгүй, гэм хоргүй, болзошгүй хор уршиг, хохирол, эрсдэлийг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлсэн, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн байна.

Дөрөв. Эрүүл мэндийн хиймэл оюуны бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн бүхий үе шат судалгаа шинжилгээнд үндэслэсэн, нотолгоонд суурилна.

ТЭГШ БОЛОМЖ

Тав. Эрүүл мэндийн хиймэл оюуны шийдэл нь олон талт байдлыг хүндэтгэн бүтээгдэхүүн төлөвлөх, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх бүх үе шатанд аливаа бүлгийг ялгаварлан гадуурхахгүй байна.

Зургаа. Эрүүл мэндийн хиймэл оюуны шийдэл нь ялгаварлан гадуурхалт, өгөгдлийн биас (bias), тоон хуваагдал, тэгш бус байдлыг бууруулахад чиглэнэ.

ИЛ ТОД БАЙДАЛ

Долоо. Эрүүл мэндийн хиймэл оюуны шийдлийн төлөвлөлт, судалгаа, өгөгдөл, хөгжүүлэлт, хэрэглээ тодийгүй түүний хязгаарлагдмал, дутмаг байдал нь олон нийт болон мэргэжлийн байгууллагуудад ойлгомжтой, хувийн нууц, төрийн нууцаас бусдаар ил тод, нээлттэй байна.

ХҮРТЭЭМЖ

Найм. Эрүүл мэндийн хиймэл оюуны шийдэл нь нийгмийн гарал, нас хүйс, нийгэм, улс төр, соёл, эдийн засгийн байдал зэргээс үл хамааран хүртээмжтэй, нийгмийн эмзэг, хэрэгцээ шаардлагатай бүлгийг дэмжсэн, татан оролцуулсан, хүн төрөлхтний тусын тулд байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Ес. Эрүүл мэндийн хиймэл оюуны аливаа бүтээгдэхүүн нь оюуны өмч, зохиогчийн эрхийн тухай зэрэг холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

Арав. Эрүүл мэндийн хиймэл оюуны бүтээгдэхүүний төлөвлөлт, судалгаа, хөгжүүлэлт, турших, нэвтрүүлэх, хэрэглэх, бүхий л үе шат нь хүн, нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийг дэмжинэ.

* * *